ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**НИЙСЛЭЛ ДЭХ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.city.audit.mn

2020.03.09 № 572

танай ____________-ны №____________-т

**НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ,ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨААТҮГ-ЫН ДАРГА, ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ С.БАТЖАРГАЛ ТАНАА**

"Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, гэрчилгээг хүргүүлж байна.

Хавсралт: 17 хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.МӨНХ-ОЧИР

002030328

D:\Documents\Documents\2020 on\ywuulsan bichig\2020.03.09.Nalaih-BMUTP.A5.docx

аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар "Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**НИЙСЛЭЛ ДЭХ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.city.audit.mn

2020.03.09 № 573

танай ____________-ны №____________-т

НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ,ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨААТҮГ-ЫН ДАРГА, ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ С.БАТЖАРГАЛ ТАНАА

## Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

"Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар "Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хетлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын Стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.МӨНХ-ОЧИР

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** НТАГ-2020/53/СТА-ОНӨААН

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2020 он

Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: Ц.Бат-Өлзий

Утас: 327734 Цахим хаяг: bat-ulziits@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цогбаяр

Утас: 315558 Цахим хаяг: tsogbayara@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Жаргалсайхан

Утас: 325093 Цахим хаяг: jargalsaikhand@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

5

# Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| НТАГ | Нийслэл дэх Төрийн аудитын газар |
| НИТХ | Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал |
| ЗД | Засаг дарга |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| ОНӨААТҮГ | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой төсөвт үйлдвэрийн газар |
| НӨҮГ | Нийслэлийн өмчит үйлдвэрийн газар |
| НӨАУГ | Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газар |
| ХХОАТ | Хувь хүний орлогын албан татвар |

## Агуулга


1. Аудитын гэрчилгээ ........ 3
2. Аудитын тайлан ........ 4
   2.1. Оршил ........ 4
   2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага ........ 4
   2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт ........ 5
   2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин ........ 5
   2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ........ 6
   2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал ........ 6
   2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар ........ 6
   2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ........ 7
   2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ........ 8
   2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн ........ 9
   2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ........ 9
   2.12. Шилэн дансны мэдээлэл ........ 9
   2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга ........ 9
   2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл ........ 9
3. Менежментийн захидал ........ 10
4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан ........ 13
   4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан ........ 16
   4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 17
   4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 18
   4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 20
   4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 21
   4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ........ 22

## 2.Аудитын тайлан

### 2.1. Оршил

"Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг газрын дарга С.Батжаргалд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус дэлгэрэнгүйлэн тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Налайх барилгын үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

"Налайхын барилгын үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 2 дугаар сарын 15-наас 2020 оны 3 дугаар сарын 12-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 3 дугаар сарын 05-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, НТАГ-ын Ахлах аудитор Д.Жаргалсайхан хариуцаж хэрэгжүүлэв.

"Налайхын барилгын үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг НТАГ-т 2020 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн 29 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах өрөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь барилгын материалын салбарт шинжлэх ухааны ололт, дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх, импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих, орчин үеийн үйлдвэрийн дэд бүтэц, бизнесийн таатай орчин бүрдүүлсэн үйлдвэрлэл, технологи, худалдаа үйлчилгээний цогцолборыг хөгжүүлэн Монгол Улс, Төвийн бүс, Нийслэл хотын эдийн засгийн өсөлт, хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд даацтай хувь нэмэр оруулахад оршино.

Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Барилгын материалын салбарт шинжлэх ухааны ололт, дэвшилтэт техник технологийг дамжуулах, нэвтрүүлэх, нутагшуулах
- Олон улсын стандартад нийцсэн импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих
- Барилгын материалын салбарын эдийн засгийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх
- Байгаль орчинд халгүй үйлдвэрлэлийг хөгжүүлэх
- Бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих
- Барилгын материалын салбарын жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжих орчныг бүрдүүлэх, ажлын байр бий болгох

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Цалин хөлстэй холбоотой Засгийн газрын 2019 оны 24, 25, 277 дугаар тогтоолууд батлагдсан.
- Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журмыг Засгийн газрын 2019 оны 07 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан.
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль /2019.03.22 Шинэчилсэн найруулга/ ХХОАТ-ын хөнгөлөлтийг цалингийн хэмжээнээс шалтгаалан 5 шатлалаар хөнгөлөлт үзүүлдэг болсон.
- Нийгмийн даатгалын шимтгэл төлөлттэй холбоотой 2019 онд ажил олгогч 12.5 хувь, даатгуулагчаас 11.5 хувь болж тус тус 0.5 хувиар нэмэгдсэн.
- Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам /Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн 271 дүгээр тогтоол/
- Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай /Хөдөлмөр нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны 2018 оны 8 дугаар сарын 19-ны өдрийн 05 дугаар тогтоол / 2019.01.01-ний өдрөөс хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 320.0 мянган төгрөг болж өөрчлөгдсөн.
- Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн паркийн хөдөлмөрийн дотоод журам

### 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

“Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨААТҮГ санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Accolous” программ хангамж ашигладаг байна.

“Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨААТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

### 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар “Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨААТҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг тодорхойлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 34 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

### 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийг өмнөх оны зардлын дүн нийт 360,380.6 мянган төгрөгөөс тооцон 7,207.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 6,818.1 мянган төгрөгөөр тооцсон нь нийт зардлын дүн өмнөх оноос 5.4 хувиар буурсантай холбоотой болно.

### 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 10,756.0 мянган төгрөгөөр буюу 4.7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0 | 0 | 0 |
| Авлага | 12,349.1 | 12,349.1 | 0 |
| Урьдчилгаа | 0 | 0 | 0 |
| Бараа материал | 18,635.2 | 17,230.2 | 1,405.0 |
| Үндсэн хөрөнгө | 22,924,415.5 | 22,915,064.5 | 9,351.0 |
| **Нийт хөрөнгө** | **22,955,399.8** | **22,944,643.8** | **10,756.0** |
| Өр төлбөр | 86.0 | 86.0 | 0 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 22,955,313.8 | 22,944,557.8 | 10,756.0 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **22,955,399.8** | **22,944,643.8** | **10,756.0** |

Авлага дансны үлдэгдэл өөрчлөгдөөгүй шалтгаан нь “Улаанбаатар бизнес хөгжлийн төв” НӨҮГ-аас (татан буугдсан) 2015 онд балансаас балансад шилжиж ирсэн түрээсийн авлага бөгөөд шүүхэд нэхэмжлэх гаргахад анхан шатны баримт нотолгоо хангалтгүй, Нийслэлийн архивын газраас мэдээлэл олдохгүй байгаа зэргээс шалтгаалан авлага барагдахгүй байна. Авлага дансны үлдэгдэлд 2009-2010 онуудад үүссэн, он удаан жил болсон 7,888.0 мянган төгрөгийн байгууллагаас авах авлага, 4,461.1 мянган төгрөгийн хувь хүнээс авах авлага байна. Үүнээс хувь хүнээс авах авлагыг барагдуулахаар шүүхэд хандаад байгаа, байгууллагаас авах авлага нь нэхэмжлэх үүсгэхэд хангалттай нотолгоогүй учир нэхэмжлэх гаргах боломжгүй бөгөөд 2020 онд хөөн хэлэлцэх хугацаа дуусахаар байгаа учир найдваргүй авлагад тусгах боломжтой болно.

Бараа материалын дансны үлдэгдэл 405.0 мянгаар буурсан нь бичиг хэргийн материал, түлш шатахууны үлдэгдлийг багаар нөөцөлсөнтэй холбоотой байна. Аж ахуйн материалын үлдэгдэл өссөн нь оффисын барилга ашиглалтын хугацааны явцад сантехник, шугам хоолойн эвдрэл гарах нь ихсэж байгаа учир зарим бага үнэтэй аж ахуйн материалуудыг нөөцлөх шалтгаан болсон. Бараа материалын тайланд нийт 26,331.8 мянган төгрөгийн орлого бүртгэсэн. Үүнээс 462.0 мянган төгрөгийн 10 ширхэг Э-токен төхөөрөмжийг Мэдээлэл, технологийн газраас албан байгууллагуудад үнэ төлбөргүй олгосныг аж ахуйн материалын дансанд бүртгэн эд хариуцагчид хүлээлгэн өгсөн. Бараа материалын дансаар 27,736.8 мянган төгрөгийн зарцуулалт хийгдэж 17,230.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Дээрх үлдэгдлийн 13,000.0 мянган төгрөг нь дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгэлтэй ажилчдын орон сууцны зураг бөгөөд 2015 онд Улаанбаатар бизнес хөгжлийн төвөөс *(татан буугдсан)* шилжиж ирсэн. Бичиг хэргийн материал, тээвэр шатахуун, аж ахуйн материалын дансдын үлдэгдлийг дараах оны нэгдүгээр сарыг дуустал төсөв нээгдэх хүртэл нөөцөлсөн.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь хуучин хөрөнгүүдийн элэгдлийн хугацаа дуусаж хуримтлагдсан элэгдэл нэмэгдэж, үлдэгдэл өртөг буурснаас шалтгаалжээ. Тайлант хугацаанд 13,701.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн. Үүнээс 9,821.8 мянган төгрөгийн өртөг бүхий 3 машины гаражийн барилгыг үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор бүртгэсэн. Гаражийн барилгыг 2018 онд бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас байгууллагын гадна тохижилтын ажлын хүрээнд ажилчдын 3 ширхэг автомашины гаражийг барьж байгуулсан. НӨАУГ-

т гаражийн барилгыг бүртгэж авах тухай зөвшөөрөл хүсэж холбогдох баримтыг явуулсан. НИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар оруулж, холбогдох тогтоол гарсан хэдий ч Нийслэлийн ЗД-ын захирамж 2019 оны 1 дүгээр сард гарсан учир энэ онд бүртгэлд тусгасан. Энэ онд 2,600.0 мянган төгрөгийн өртөг бүхий зөөврийн компьютер худалдан авч бүртгэлд тусгасан. Мөн авто тээврийн хэрэгсэл дансанд бүртгэлтэй Соната-6 автомашины мотор цохиж эвдэрсэн учир 1,280.0 мянган төгрөгөөр мотор солиулж, машины өртгийг капиталжуулан 21,280.0 мянган төгрөгийн өртөгтэй болгосон.

Өр төлбөр дансны үлдэгдэл өөрчлөлтгүй хэвээр байна. Тайлант хугацаанд шинээр нэмэгдсэн болон хасагдсан өр төлбөргүй 86.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Дээрх өр төлбөр нь 2015 онд Улаанбаатар бизнес хөгжлийн төвөөс *(татан буугдсан)* шилжиж ирсэн бөгөөд “Номин хүрд” ХХК-д түрээсийн төлбөрийн зөрүүг буцаан олгох байсан боловч олгоогүй учир өр үүссэн. Дээрх компанийг цагдаагийн газраас эрэн сурвалжлахад олдохгүй байгаа учир төлбөрийн барагдуулах боломжгүй нөхцөл үүсээд байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 22,944,557.8 мянган төгрөг болж 10,756.0 мянган төгрөгөөр буурсан нь эргэлтийн бус хөрөнгө ихтэй учир элэгдлийн зардал их гарч тайлант хугацааны үр дүнгээр буурсан байна. Энэ нь засгийн газрын хувь оролцоог тайлант үеийн үр дүнгээр бууруулах шалтгаан болж байна.

## 2.4. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 319,764.9 мянган төгрөгийн төсөв батлагдсан. 319,764.9 мянган төгрөгийн зардлын санхүүжилтийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөсөн.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 311,672.9 мянган төгрөг буюу 97.5 хувьтай байгаа нь орон тоо 3 хүнээр дутуу ажилласнаас цалингийн зардлаас 6,700.0 мянга, нийгмийн даатгалаас 839.4 мянган төгрөгийн хэмнэлт гарсан, оффиссийн байрны 2 дугаар давхарын халаалтын хааж, бүх үйл ажиллагаагаа 1 дүгээр давхарт төвлөрүүлсэн зэргээс шалтгаалсан байна. Төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 8,091.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

## 2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 36 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд нэмж эрсдэл илрээгүй 5 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 25,933.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 23,395.2 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 2,538.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Аудитаар илэрсэн 2,538.7 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

**2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Тус байгууллагын 2019 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж нөшгөн шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

**2.12. Шилэн дансны мэдээлэл**

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 30 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

**2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх аудитаар өгсөн 1 зөвлөмж хэрэгжүүлж ажилласан байна.

**2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид "Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨААТҮГ 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

"Зөрчилгүй" дүгнэлт

"Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, хөрөнгийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

## 3.Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### 3.1 Зардалтай холбоотой асуудал

#### 3.1.1 Илрүүлэлт:

- Бичиг хэргийн материалын орлого, зарлагын гүйлгээний дүнг эд хариуцагчийн тайланд 2,538.7 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн. Энэ нь үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 "*Үнэн зөв байх*" заалтыг зөрчсөн байна.

#### 3.1.2 Эрсдэл:

- Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх;

#### 3.1.3 Өгсөн зөвлөмж:

- Бараа материалын орлого, зарлагын гүйлгээг тухай бүр анхан шатны баримтыг үндэслэн бүртгэлд тусгаж тайлагнаж байх;

#### 3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

- ТШЗ-ийн зүгээс зөрчлийг цаашид давтан гаргахгүй ажиллах талаар хариу ирүүлсэн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 5 дугаар ...ын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал ...эрхийлье.

**АУДИТЫН ТАЙЛАНГ**

**Хянасан:**

Санхүүгийн аудитын хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер — Ц.Бат-Өлзий

Аудитын менежер — А.Цогбаяр

1117145633
УХА0612 9077278

**Бэлтгэсэн:**

Ахлах аудитор — Д.Жаргалсайхан

## Үйлчлүүлэгч байгууллагын хариу:

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

**НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨААТҮГ**

Өерийн байр, 3 дугаар хороо,
Налайх дүүрэг, Улаанбаатар хот, 12609-0017
Утас: 7575-1001
E-mail: park@nad.ub.gov.mn
http://www.nalaikhpark.mn

2020.03.05 № 95

танай________________-ны № ________________ -т

Хариу хүргүүлэх тухай

Нийслэл дэх төрийн аудитын газраас ирүүлсэн 2019 оны санхүүгийн тайланд илэрсэн зөрчил, асуудлын бүртгэлтэй танилцлаа. Асуудлын бүртгэлээр илэрсэн зөрчлүүдийг давтан гаргахгүй байхад анхаарч, цаашид холбогдох хууль тогтоомж, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

ДАРГА С.БАТЖАРГАЛ

## 4.Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

### 4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

...айлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|
| **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **30 984 321.21** | **29 579 289.21** |
| **АВЛАГА** | 12 349 119.21 | 12 349 119.21 |
| **Бусад авлага** | 12 349 119.21 | 12 349 119.21 |
| Байгууллагаас авах авлага | 7 888 000.21 | 7 888 000.21 |
| Хувь хүмүүсээс авах авлага | 4 461 119.00 | 4 461 119.00 |
| **БАРАА МАТЕРИАЛ** | 18 635 202.00 | 17 230 170.00 |
| Дуусаагүй үйлдвэрлэл | 13 000 000.00 | 13 000 000.00 |
| **Хангамжийн материал** | 5 635 202.00 | 4 230 170.00 |
| Бичиг хэргийн материал | 1 338 670.00 | 483 220.00 |
| Аж ахуйн материал | - | 1 726 950.00 |
| Түлш, шатах тослох материал | 4 296 532.00 | 2 020 000.00 |
| **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **22 924 415 456.98** | **22 915 064 483.87** |
| **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 22 924 415 456.98 | 22 915 064 483.87 |
| **Биет хөрөнгө** | 684 509 457.10 | 675 388 484.03 |
| Барилга, байгууламж, орон сууц | 715 851 522.00 | 725 673 378.00 |
| Хуримтлагдсан элэгдэл | (43 549 824.78) | (61 671 197.06) |
| Авто-тээврийн хэрэгсэл | 20 000 000.00 | 21 280 000.00 |
| Хуримтлагдсан элэгдэл | (20 000 000.00) | (20 000 000.00) |
| Машин тоног төхөөрөмж (компьютер) | 35 309 000.00 | 37 909 000.00 |
| Хуримтлагдсан элэгдэл | (32 980 698.84) | (34 488 504.30) |
| Тавилга, аж ахуйн эд хогшил | 30 991 100.00 | 30 991 100.00 |
| Хуримтлагдсан элэгдэл | (21 659 002.93) | (24 726 642.61) |
| Бусад үндсэн хөрөнгө | 1 276 790.00 | 1 276 790.00 |
| Хуримтлагдсан элэгдэл | (729 428.35) | (855 440.00) |
| **Биет бус хөрөнгө** | 22 239 905 999.88 | 22 239 675 999.84 |
| Програм хангамж | 3 870 000.00 | 3 870 000.00 |
| Хуримтлагдсан элэгдэл | (2 260 000.12) | (2 490 000.16) |
| Бусад биет бус хөрөнгө | 22 238 296 000.00 | 22 238 296 000.00 |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **22 955 399 778.19** | **22 944 643 773.08** |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **86 000.00** | **86 000.00** |
| **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 86 000.00 | 86 000.00 |
| **Өглөг** | 86 000.00 | 86 000.00 |
| **Бусад өглөг** | 86 000.00 | 86 000.00 |
| Байгууллагад төлөх өглөг | 86 000.00 | 86 000.00 |
| **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **22 955 313 778.19** | **22 944 557 773.08** |
| **Засгийн газрын хувь оролцоо** | 22 955 313 778.19 | 22 944 557 773.08 |
| Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 22 238 296 000.00 | 22 238 296 000.00 |
| Өмч:- төрийн | 22 238 296 000.00 | 22 238 296 000.00 |
| **Хуримтлагдсан үр дүн** | 717 017 778.19 | 706 261 773.08 |
| Өмнөх үеийн үр дүн | 743 964 702.12 | 717 017 778.19 |
| Тайлант үеийн үр дүн | (26 946 923.93) | (10 756 005.11) |
| **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **22 955 399 778.19** | **22 944 643 773.08** |

## 4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **333 433 700.00** | **330 147 756.00** |
| **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **-** | **10 382 856.00** |
| Төсөвт байгууллагын өөрийн орлого | - | 9 920 856.00 |
| Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 99 000.00 |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | - | 9 821 856.00 |
| Хандив тусламж /дотоод/ | - | 462 000.00 |
| **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **333 433 700.00** | **319 764 900.00** |
| Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 333 433 700.00 | 319 764 900.00 |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **360 341 041.43** | **340 903 761.11** |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | **360 341 041.43** | **340 903 761.11** |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 333 834 532.33 | 330 712 826.98 |
| **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 187 383 113.00 | 170 300 423.00 |
| Үндсэн цалин | 125 898 313.00 | 170 300 423.00 |
| Нэмэгдэл | 50 982 000.00 | - |
| Унаа хоолны хөнгөлөлт | 10 502 800.00 | - |
| **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 22 717 079.69 | 21 284 419.00 |
| Тэтгэврийн даатгал | 17 590 390.69 | 14 473 410.00 |
| Тэтгэмжийн даатгал | 927 600.00 | 1 702 755.00 |
| ҮОМШӨ-ний даатгал | 618 499.31 | 1 362 204.00 |
| Ажилгүйдлийн даатгал | 30 900.69 | 340 543.00 |
| Эрүүл мэндийн даатгал | 3 549 689.00 | 3 405 507.00 |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 24 737 949.20 | 37 989 713.00 |
| Гэрэл, цахилгаан | 15 560 949.20 | 24 074 513.00 |
| Цэвэр, бохир ус | 5 277 000.00 | 5 275 200.00 |
| Байрны түрээс | 3 900 000.00 | 8 640 000.00 |
| **Хангамж, бараа материалын зардал** | 25 749 471.38 | 32 678 292.87 |
| Бичиг хэрэг | 5 704 880.00 | 6 142 230.00 |
| Тээвэр, шатахуун | 7 908 735.37 | 10 576 532.00 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3 939 436.01 | 4 941 465.87 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 8 196 420.00 | 11 018 065.00 |
| Урсгал засвар | - | 150 000.00 |
| Дотоод албан томилолт | 1 000 000.00 | - |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 45 285 213.00 | 44 725 770.00 |
| Даатгалын үйлчилгээ | 118 800.00 | 131 280.00 |
| Тээврийн хэрэгслийн татвар | 71 500.00 | 70 100.00 |
| Тээврийн хэрэгслийн оношлогоо | 20 000.00 | 60 000.00 |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | 26 751 406.06 | 23 322 829.11 |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 270 000.00 |
| Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 26 751 406.06 | 23 052 829.11 |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 26 506 509.10 | 10 190 934.13 |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1 950 000.00 | 2 000 000.00 |
| Төвлөрүүлэх шилжүүлэг | 24 556 509.10 | 8 190 934.13 |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(26 907 341.43)** | **(10 756 005.11)** |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 39 582.50 | - |
| Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 39 582.50 | - |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (39 582.50) | - |
| **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(26 946 923.93)** | **(10 756 005.11)** |

## 4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **336 495 175.00** | **319 863 900.00** |
| **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1 000 000.00** | **99 000.00** |
| **Нийтлэг татварын бус орлого** | 1 000 000.00 | 99 000.00 |
| **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 1 000 000.00 | 99 000.00 |
| Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1 000 000.00 | 99 000.00 |
| **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **335 495 175.00** | **319 764 900.00** |
| **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 333 433 700.00 | 319 764 900.00 |
| Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 333 433 700.00 | 319 764 900.00 |
| **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 2 061 475.00 | - |
| Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 2 061 475.00 | - |
| **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **336 495 175.00** | **319 863 900.00** |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | **336 495 175.00** | **319 863 900.00** |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **307 927 190.90** | **309 672 965.87** |
| **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 187 383 113.00 | 170 300 423.00 |
| Үндсэн цалин | 125 898 313.00 | 123 510 423.00 |
| Нэмэгдэл | 50 982 000.00 | 29 850 000.00 |
| Унаа хоолны хөнгөлөлт | 10 502 800.00 | 16 940 000.00 |
| **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 22 717 079.69 | 21 284 419.00 |
| Тэтгэврийн даатгал | 17 590 390.69 | 15 317 518.00 |
| Тэтгэмжийн даатгал | 927 600.00 | 1 689 139.00 |
| ҮОМШӨ-ний даатгал | 618 500.00 | - |
| Ажилгүйдлийн даатгал | 30 900.00 | - |
| Эрүүл мэндийн даатгал | 3 549 689.00 | 4 277 762.00 |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 24 737 949.20 | 37 989 713.00 |
| Гэрэл, цахилгаан | 15 560 949.20 | 24 074 513.00 |
| Цэвэр, бохир ус | 5 277 000.00 | 5 275 200.00 |
| Байрны түрээс | 3 900 000.00 | 8 640 000.00 |
| **Хангамж, бараа материалын зардал** | 21 076 436.01 | 23 431 260.87 |
| Бичиг хэрэг | 6 000 000.00 | 5 286 780.00 |
| Түлш, шатахуун | 10 000 000.00 | 8 300 000.00 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3 939 436.01 | 4 941 465.87 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1 137 000.00 | 4 903 015.00 |
| **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2 820 000.00 | 5 510 000.00 |
| Тавилга, техник, хэрэгсэл | 2 820 000.00 | 2 600 000.00 |
| Урсгал засвар | - | 2 910 000.00 |
| **Томилолт, зочны зардал** | 1 000 000.00 | - |
| Дотоод албан томилолт | 1 000 000.00 | - |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 48 192 613.00 | 50 887 150.00 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 47 982 313.00 | 50 625 770.00 |
| Даатгалын үйлчилгээ | 118 800.00 | 131 280.00 |
| Тээврийн хэрэгслийн татвар | 71 500.00 | 70 100.00 |
| Тээврийн хэрэгслийн оношлогоо | 20 000.00 | 60 000.00 |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | - | 270 000.00 |
| Мэргэжил үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 270 000.00 |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **28 567 984.10** | **10 190 934.13** |
| **Бусад урсгал шилжүүлэг** | 4 011 475.00 | 2 000 000.00 |

| | | |
|---|---|---|
| ...гийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 2 061 475.00 | - |
| ... удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1 950 000.00 | 2 000 000.00 |
| **... нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох ...с, санхүүжилт** | 24 556 509.10 | 8 190 934.13 |
| ...ээрүүлэх шилжүүлэг | 24 556 509.10 | 8 190 934.13 |
| **...ЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| **...гө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| **...гө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

## 4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

...ант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газр... хувь оролцо... нийт дүн |
|---|---|---|---|---|
| **... 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 0.00 | 0.00 | 743 964 702.12 | 743 964 702... |
| ...бодох бүртгэлийн бодлогын ... | 0.00 | 0.00 | 0.00 | 0... |
| **...рхийлсэн үлдэгдэл** | **0.00** | **0.00** | **743 964 702.12** | 743 964 702... |
| ...рөнгийн дахин үнэлгээний ... | 22 238 296 000.00 | 0.00 | 0.00 | 0... |
| ...рөнгийн дахин үнэлгээний ... | 0.00 | 0.00 | 0.00 | 0... |
| ... тайланд хүлээн ...гүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0... |
| ...ийн үр дүн | 0.00 | 0.00 | -26 946 923.93 | 22 211 349 076... |
| **... 12-р сарын 31-нээрх ...** | **22 238 296 000.00** | **0.00** | **717 017 778.19** | 22 955 313 778... |
| **... 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **22 238 296 000.00** | **0.00** | **717 017 778.19** | 22 955 313 778... |
| ...бодох бүртгэлийн бодлогын ... | 0.00 | 0.00 | 0.00 | 0... |
| **...рхийлсэн үлдэгдэл** | **22 238 296 000.00** | **0.00** | **717 017 778.19** | 22 955 313 778... |
| ...рөнгийн дахин үнэлгээний ...уралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0... |
| ...рөнгийн өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0... |
| ... тайланд хүлээн ...гүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0... |
| ...алютын хөрвүүлэлтийн зөрүү | 0.00 | 0.00 | 0.00 | 0... |
| ...ийн үр дүн | 0.00 | 0.00 | -10 756 005.11 | -10 756 005... |
| **... 12-р сарын 31-нээрх ...** | **22 238 296 000.00** | **0.00** | **706 261 773.08** | 22 944 557 773... |

## 4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

…лант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| …үзэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| **…йт ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 319 764 900.00 | 311 672 965.87 | 8 091 934.13 | 97.47 |
| **…РСГАЛ ЗАРДАЛ** | 319 764 900.00 | 311 672 965.87 | 8 091 934.13 | 97.47 |
| **…РАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 317 764 900.00 | 309 672 965.87 | 8 091 934.13 | 97.45 |
| **…н хөлс болон нэмэгдэл урамшил** | 176 990 000.00 | 170 300 423.00 | 6 689 577.00 | 96.22 |
| …сэн цалин | 130 200 000.00 | 123 510 423.00 | 6 689 577.00 | 94.86 |
| …гдэл | 29 850 000.00 | 29 850 000.00 | - | 100.00 |
| …а хоолны хөнгөлөлт | 16 940 000.00 | 16 940 000.00 | - | 100.00 |
| **…л олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 22 123 800.00 | 21 284 419.00 | 839 381.00 | 96.21 |
| …эврийн даатгал | 15 044 200.00 | 15 317 518.00 | (273 318.00) | 101.82 |
| …эмжийн даатгал | 1 769 900.00 | 1 689 139.00 | 80 761.00 | 95.44 |
| …МШӨ-ний даатгал | 1 415 900.00 | - | 1 415 900.00 | - |
| …лгүйдлийн даатгал | 354 000.00 | - | 354 000.00 | - |
| …л мэндийн даатгал | 3 539 800.00 | 4 277 762.00 | (737 962.00) | 120.85 |
| **…р ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 38 010 900.00 | 37 989 713.00 | 21 187.00 | 99.94 |
| …эл, цахилгаан | 24 090 900.00 | 24 074 513.00 | 16 387.00 | 99.93 |
| …эр, бохир ус | 5 280 000.00 | 5 275 200.00 | 4 800.00 | 99.91 |
| …ны түрээс | 8 640 000.00 | 8 640 000.00 | - | 100.00 |
| **…гамж, бараа материалын зардал** | 23 432 000.00 | 23 431 260.87 | 739.13 | 100.00 |
| …г хэрэг | 5 500 000.00 | 5 286 780.00 | 213 220.00 | 96.12 |
| …эр, шатахуун | 12 000 000.00 | 8 300 000.00 | 3 700 000.00 | 69.17 |
| …удан, холбоо, интернэтийн төлбөр | 4 932 000.00 | 4 941 465.87 | (9 465.87) | 100.19 |
| …а үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1 000 000.00 | 4 903 015.00 | (3 903 015.00) | 490.30 |
| **…хогшил, урсгал засварын зардал** | 5 510 000.00 | 5 510 000.00 | - | 100.00 |
| …ж, техник, хэрэгсэл | 2 600 000.00 | 2 600 000.00 | - | 100.00 |
| …гал засвар | 2 910 000.00 | 2 910 000.00 | - | 100.00 |
| **…илолт, зочны зардал** | - | - | - | #DIV/0! |
| …оод албан томилолт | - | - | - | #DIV/0! |
| **…лаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, …амж** | 51 218 200.00 | 50 887 150.00 | 331 050.00 | 99.35 |
| …лаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил …лчилгээний төлбөр хураамж | 50 700 000.00 | 50 625 770.00 | 74 230.00 | 99.85 |
| …галын үйлчилгээ | 248 600.00 | 131 280.00 | 117 320.00 | 52.81 |
| …врийн хэрэгслийн татвар | 129 600.00 | 70 100.00 | 59 500.00 | 54.09 |
| …врийн хэрэгслийн оношлогоо | 140 000.00 | 60 000.00 | 80 000.00 | 42.86 |
| **…а үйлчилгээний бусад зардал** | 480 000.00 | 270 000.00 | 210 000.00 | 56.25 |
| …эл үйлдвэрлэлийн дадлага хийх | 480 000.00 | 270 000.00 | 210 000.00 | 56.25 |
| **…РСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 2 000 000.00 | 2 000 000.00 | - | 100.00 |
| **…ад урсгал шилжүүлэг** | 2 000 000.00 | 2 000 000.00 | - | 100.00 |
| … удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2 000 000.00 | 2 000 000.00 | - | 100.00 |
| **…РДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 319 764 900.00 | 311 672 965.87 | 8 091 934.13 | 97.47 |
| **…СЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 319 764 900.00 | 311 672 965.87 | 8 091 934.13 | 97.47 |
| …сын төсвөөс санхүүжих | 319 764 900.00 | 311 672 965.87 | 8 091 934.13 | 97.47 |
| **…АЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.00 | 1.00 | - | 100.00 |
| …свийн байгууллага | 1.00 | 1.00 | - | 100.00 |
| **…ЖИЛЛАГСАДЫН ТОО** | 14.00 | 14.00 | - | 100.00 |
| …рдах ажилтан | 1.00 | 1.00 | - | 100.00 |
| …цэтгэх ажилтан | 12.00 | 12.00 | - | 100.00 |
| …члэх ажилтан | 1.00 | 1.00 | - | 100.00 |
| …сын албаны албан хаагч (АА)* | 1.00 | 1.00 | - | 100.00 |